

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 03 дугаар  
сарын 04 -ны өдөр

Дугаар 24 / А / 62

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 757 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Т.Жамбаажамц), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй,  
дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ны  
өдрийн 94 /А/62 дугаар хамтарсан тушаалын хавсралт

## **ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН БАГЦЫГ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Үл хөдлөх хөрөнгийн барьцаатай баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны шийдвэрийг үндэслэн уг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан тухай тусгай тэмдэглэл хийж, эрхийн улсын бүртгэлд бүртгэх болон газар эзэмших эрхийн гэрчилгээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой тусгай тэмдэглэл хийж, бүртгэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 1.1-д заасан тусгай тэмдэглэлийг хийхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Газрын тухай хууль, Засгийн газраас баталсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх” журам болон энэ журмыг мөрдлөг болгоно.

### **ХОЁР.ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙХ**

2.1.Улсын бүртгэгч нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 30.1.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасныг тус тус үндэслэн эрхийн улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийнэ.

2.2.Эрх шилжүүлэн авч байгаа этгээд (цаашид “тусгай зориулалтын компани” гэх) тусгай тэмдэглэл хийлгэх тухай хүсэлтийг Хорооны шийдвэрт үндэслэн дараах баримт бичгийн хамт улсын бүртгэлийн байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

2.2.1.баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэрийн хуулбар;

2.2.2.Хороонд бүртгүүлсэн хөрөнгийн багц дахь үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар, хаяг, хэмжээ, зориулалт, зээлийн болон барьцааны гэрээний огноо, дугаарыг тусгасан жагсаалт;

2.2.3.хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн гэрээ, эсхүл улсын бүртгэлийн байгууллагаас баталсан хүсэлтийн маягт;

2.3.Улсын бүртгэгч нь энэ журмын 2.2-т заасан хүсэлт, холбогдох баримт, материалыг хүлээн авч тухайн үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн батлагдсан маягтын дагуу бүртгэлийг хөтлөн хувийн хэрэгт хавсаргана.

2.4.Улсын бүртгэгч бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хариу мэдэгдэнэ:

2.4.1.эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэсэн тухай;

2.4.2.эрхийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах тухай шийдвэрийг үндэслэл бүхий тайлбарын хамт.

2.5.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой

тусгай тэмдэглэл хийхдээ энэ журмын 2.2-т заасан холбогдох баримт, материалыг хүлээн авч, газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй тухайн эзэмшил газрын мэдээлэлд тэмдэглэл хийж “тусгай тэмдэглэл” гэсэн бүртгэл үүсгэнэ.

2.6. Тусгай зориулалтын компани өөрийн хүсэлтээр бүртгүүлсэн тусгай тэмдэглэл болон Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.6-д заасан бусад дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

## ГУРАВ. ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ БОЛОН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

3.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан үүрэг гүйцэтгэгчийн үүрэг дуусгавар болж, тусгай зориулалтын компани, эсхүл түүний эрх олгосон хөрөнгө итгэмжлэн удирдагчаас тусгай тэмдэглэлийг хүчингүй болгох хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Хорооны шийдвэрээр улсын бүртгэгч нь энэ журамд заасан тусгай тэмдэглэл болон эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.6-д заасан тусгай тэмдэглэлийг хүчингүй болгох хүсэлтийг улсын бүртгэлийн байгууллагад дараах баримт бичгийн хамт цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

3.2.1. Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хуульд заасны дагуу дуусгавар болсныг нотлох гэрээ болон бусад баримт, материал;

3.2.2. Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт.

3.3. Улсын бүртгэгч нь энэ журмын 3.2-т заасан хүчингүй болгуулах хүсэлт, баримт бичгийг хүлээн авсан тохиолдолд эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, бүртгэлийг дуусгавар болгох бөгөөд хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хариу мэдэгдэнэ.

---oOo---